

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 06-ны өдөр

Дугаар БА-045/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 2 давхар 1 блок бүхий хүчин чадалтай Эрүүл мэндийн төвийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/04/18 огноо, Зөвшөөрлийн дугаар 0014849, БАЗГ2024/0225
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр:ТГ-22/004
- 2.3. Захиалагч: Эрүүл мэндийн яам оноосон нэр, 9070006111 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9087443 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 14210, Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2, 51-263734
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Пи Эм" ХХК оноосон нэр, 9011052108 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5027543 регистрийн дугаар, БУ16-27/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Соёлын төв өргөө 1 давхар, 99109955, 99040058 холбоо барих утас;
- 2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: "Мега Ом Инж" ХХК оноосон нэр, 9020101044 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2819457 регистрийн дугаар, 219/21 ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4 дугаар хороо, 15-р хороолол, 9,24, 99099421 холбоо барих утас;
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Төгс гранд констракшн" ХХК оноосон нэр, 9011606113 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6063721 регистрийн дугаар, ЗТ17-114/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд  
оруулах комисс

дүгээр хороо, 7-р хороолол, ногоон нуур, 225, 42 тоот, 80055733, 99041663 холбоо барих утас

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв оноосон нэр, 000012896 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9096566 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Төвийн хэсэг, 77533665, 80004303 холбоо барих утас

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 2 давхар 1 блок бүхий хүчин чадалтай эрүүл мэндийн төвийн зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь: Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

АШИГЛАЛТЫН  
ГАЗАР  
Барилга байгууламжийг ашиг  
оруулах комисс



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРОО, ГАЧУУРТ ТОСГОНЫ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ  
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга  
угсралтын ажлыг ашиглалтанд оруулах комиссын хуралдаан 2025 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр 10:00 цагт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын  
барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн дарга

А.Мөнгөн

2. Комиссын нарийн бичгийн дарга:

Барилгын Хөгжлийн Төвийн  
ББЗХХэлтсийн хяналтын инженер

Г.Батбаяр

Комиссын гишүүд:

3. Нийслэлийн хяналт шалгалтын газар,  
Барилгын стандарт, аюулгүй байдлын  
хяналтын хэлтсийн дарга

Г.Батбаатар

4. Архивын ерөнхий газрын архивч

Б.Оюунжаргал

5. Ашиглагч байгууллага:

Гачуурт тосгоны Эрүүл мэндийн  
төвийн дарга

Б.Бат-Амгалан

6. Зураг төсөл зохиогч байгууллага:

Төгс Гранд Констракшн ХХК-ийн захирал

П.Ундармаа

7. Нийслэлийн хяналт, шалгалтын газрын  
Дэд бүтцийн стандарт хяналтын хяналтын  
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Э.Цогцолмаа

8. УБЦТС ТӨХК-ийн техник хяналтын инженер

Б.Цэрэннадмид

9. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн  
Технологийн удирдлагын төлөвлөлтийн газар  
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн

Н.Болор-Эрдэнэ

10. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын  
Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн  
Хэлтсийн инженер

Г.Уртнасан

11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг  
Хамгаалах байгууллагын төлөөлөл

Б.Ганзориг

12. Гачуурт тосгоны ЗДТГ-ын аж ахуйн алба

Б.Лувсандагва

13. "ПиЭм"ХХК-ийн захирал

Д.Түмэндүүрэн

Барилга байгууламжийг ашиглалтанд  
оруулах комисс

#### ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 13
- Хүрэлцэн ирсэн – 13 /100%/
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 13

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын баримт бичгийн бүрдэл, ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав. Гачуурт тосгоны ЭМТөвийн дарга:

##### **Б.Бат-Амгалан**

- Ажлын төсвийн нэгдсэн товчоонд тусгасан 134,321,728 төгрөгийн тоног төхөөрөмжийг техникийн үзүүлэлт чанарын баталгааны хугацааг тусган актаар хүлээлцэх
- Барилгын онцгой бүтээц шаварлаг, шилэн эдлэлд аюулгүй ажиллагааны баталгааг чанарын баталгаанаас тусад нь гаргаж өгөх;
- Сувилагчийн дуудлагын систем бүрэн байршуулах;
- Дутуу тоноглол гүйцээж угаалтуурууд, 32-ийн дэлгэц 2ш;
- Зурагт өөрчлөлт орсон хэсгийг зохиогчтой албан бичгээр баталгаажуулах;
- Вакцин, тарианы өрөө гэх мэт онцгой хэсэгт стандарт зөрчиж эмульс хийсэн байдалд зураг төсөв зохиогч албан бичгээр өгөх;
- Бичиг баримтын бүрдэл хангах;
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад авах;

Зураг төсөл зохиогч байгууллага: Төгс Гранд Констракшн ХХК-ийн захирал

##### **П.Ундармаа**

- Узелийн өрөөний тоног төхөөрөмжийг хаягжуулах;
- Цахилгаан зуухны аюулгүй ажиллагаа дүрмийг нийлүүлэгчээс авч байршуулах;
- Гадна зогсоолын зам талбайн тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байршуулах;
- Дотор шилэн хананд зураг төслийн дагуу наалт наах;
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах саналтай байна;

Гүйцэтгэгч байгууллага: Пи Эм ХХК-ийн захирал

##### **Д.Түмэндүүрэн**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелэлтээр, байнгын ашиглалтанд оруулах;

БЗД-ийн Гачуурт тосгоны ЗДТГ-ын ажилтан



**Б.Лувсандагва:**

- Засаг даргын тамгын газраас өгсөн үүрэг даалгавар хэвийн хийсэн;
- Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад авах;

Барилгын Хөгжлийн Төвийн хяналтын инженер

**Г.Батбаяр:**

- Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангуулж ашиглалтад оруулах;
- Баримт бичгийн бүрдэл хангах;
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад авах;

Барилгын Хөгжлийн Төвийн барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер

**Г.Уртнасан**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативийг сангийн төлбөрийг төлөх;
- Ашиглагч байгууллагад хувийн хэрэг нээж, холбогдох баримт, бичиг баримтын иж бүрэн зураг төсөл актаар хүлээлцэх;
- Хуучин барилгын буулгалтын ажлын зөвшөөрөл, холбогдсон бичиг баримт нөхөж үзүүлэх
- Барилгын эргэн тойронд хийгдсэн шатанд бариул хийх;
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад авах;

Үндэсний төв архивын архивч

**Б.Оюунжаргал**

- Хувийн хэрэг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх;
- Ажлын зургийг зургийн бүрдлийн дагуу гадна дотор ажлын зургаар ангилж хавтаслаж өгөх;
- Барилга угсралтын ил далд ажлын актыг гэрэл зургийн хамт хэрэг үүсгэн, ажлын дарааллаар дотоод товъёг үйлдэн өгөх;
- БУАжлын тэмдэглэл, дэвтэр бүрэн баталгаажуулж хаягжуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Мэдээлэл Холбоо Сүлжээ ХХК-ийн ДБТХэлтсийн мэргэжилтэн

**Н.Болор-Эрдэнэ**

- Зарлан мэдээллэх системийн ил далд ажлын акт бүрдүүлэх;
- Сувилагч дуудлагын системийг угсарч хэвийн ажиллагаанд оруулах (акт бүрдүүлэх);
- Давхрын самбруудын сүлжээний утаснуудыг хаягжуулах;
- Тог баригч суурьлуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага МХҮХ-ийн ерөнхийлөгч

**Б.Ганзориг**

АНАЛТ

а байгуу  
оруу

- Авто зогсоол дээр тэмдэг тэмдэглэгээ хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийж төлөвлөж гүйцэтгэх;
- Авто замаас явган хүний зам руу явах налуууг хийх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

УБЦТС ТӨХК-ийн техник хяналтын инженер

**Б.Цэрэннадмид**

- Ерөнхий оролтын самбар, хувиарлах самбаруудад хаяг бичиглэл хийх, схем байршуулах;
- Давхрын самбаруудад аюулгүй ажиллагааны анхааруулах плакат хадах;
- Аянга хүлээн авах антен хийх;
- 0,4кв ЦДКШ-н трассыг холбогдох байгууллагуудаар хянуулж батлуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

НОБГ БЗТХяналтын ахлах байцаагч, хошууч

**Б.Даваасүрэн**

- Гадна дулаалгын дүгнэлт үзүүлэх;
- Галын дохиоллын систем батлагдсан зургийн дагуу хийх, хамгаалах таг авах. Шалгасан акт, фото зураг;
- ГК холбох тотго, хомут солих, ус тавьж шалгах;
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж MNS 5566:2020 стандартын дагуу байрлуулах;
- Цахилгаан шатны өрөөнд автомат бие даасан гал унтраах модулын систем төлөвлөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Нийслэлийн Хяналт Шалгалтын Газрын дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч

**Э.Цогзолмаа**

- Дулаан хангамжийн өөрчлөлтийн зургийг үзүүлэх;
- Узелийн өрөөнд угсрагдсан коллекторыг хаягжуулах;
- Чайник шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргуулах;
- АС болон дулааны шугам сүлжээ угсралтын ил далд акт шалгуулах;
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Нийслэлийн Хяналт Шалгалтын Газар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

**Г.Батбаатар**

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үзүүлэх;
- Барилгад хэрэглэсэн арматурын шинжилгээг үзүүлэх;
- Ногоон байгууламжийг ЗТ-д заасны дагуу хийж үзүүлэх;

- Барилгад хэрэглэсэн материалын ТГ, сертификатыг монгол хэлээр үзүүлэх; цонх, хаалга, шал, будаг, шилэн хаалга;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Нийслэлийн Хяналт Шалгалтын Газар, ББАБХ-ийн дарга

**А.Мөнгөн**

- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гарган албан бичгээр ирүүлэх;
- Гадна ногоон байгууламжийн ажлыг технологийн хугацаанд хийж гүйцэтгэх баталгаа албан бичиг ирүүлэх;
- Гадна авто зогсоол, авто замын тэмдэг тэмдэглэгээг хийх;
- Явган хүний замын ХБИ зориулсан хотын замын стандартын дагуу болгож засах;
- Дутуу суурьлуулсан болон холболт хийгдээгүй тоноглолуудыг гүйцээж хийх, фото зургаар баримтжуулж ирүүлэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах


**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан.

Комиссын дарга:

Хотын стандарт, хяналтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн дарга



/А.Мөнгөн/

Тэмдэглэл хөтөлсөн.

Комиссын нарийн бичгийн дарга:

Барилгын Хөгжлийн Төвийн  
хяналтын инженер

/Г.Батбаяр/

